

СУРГАЛТЫН ГЭРЭЭ

№ _____

2024 оны __ сарын __ өдөр

Улаанбаатар хот

Гэрээний үндсэн нөхцөл

Энэхүү сургалтын гэрээг Чингэлтэй дүүрэг 5-р хороо, 6р хороолол Оранж Плаза 9 давхар 905 тоот 6479731 Регистрийн дугаартай “Ю Кью И инженеринг” компаний харьяат ТЭЕЕ Сургууль (цаашид “Сургууль” гэх) ангийн хөтөлбөрийн сургалтын үйлчилгээ авахыг зөвшөөрсөн овогтой сурагчийг төлөөлж овогтой- тай байгуулав.

Энэхүү гэрээнд дурдсан нөхцөлийн дагуу Сургууль нь суралцагчийн сонгосон сургалтын хөтөлбөрийн дагуу тодорхой заасан хугацаагаар сургалтын үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрч байна.

1. Нийтлэг үндэслэл

1.1. Сургууль нь суралцагчид Дижитал технологийн хичээлийн хөтөлбөрийг (Цаашид Сургалт гэх) өөрийн байранд заах бөгөөд энэхүү гэрээ нь батлагдсан өдрөөс эхэлж сургалтын хугацаа дуустал хүчинтэй байна.

2. Сургалтын хугацаа, төлбөр

- Сургалт нь 2023 оны 9 сарын 16 өдрөөс 2024 оны 6 сарын 8 өдрийг хүртэл нийт 32 долоо хоногийн 64 цагийн хичээл орно.
- Багш сурагчийн харьцаа 12:1 буюу нэг багшид ногдох хүүхдийн тоо арван хоёроос илүүгүй байна.
- Сургалтын төлбөр 1500'000 ₮ (нэг сая таван зуун мянган төгрөг) үүнд сургалтад ашиглах тоног төхөөрөмж болон бусад зардал багтсан болно.
- Хөнгөлөлттэй суралцах тохиолдолд үндсэн төлбөрөөс хувь хөнгөлөгдөж төлбөрийг төлнө.

3.Төлбөрийн нөхцөл

- 3.1.Төлөөлөгч нь гэрээ байгуулагдсанаар төлбөрийг “Хаан Банк” 5041 566 630 тоот Борхүү овогтой Билгүүн дансанд шилжүүлнэ. Гүйлгээний утга: Сурагчийн регистерийн дугаар
- 3.2.Сургалтын төлбөрийг гэрээ хийснээс 3 хоногийн дотор бүрэн шилжүүлнэ, эсхүл ПокетЗеро, ОмниВэй, Соно, Сторпэй аппликэйшнүүдээр дамжуулан төлнө.
- 3.3.Сургалтын төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд гэрээг цуцлагдсанд тооцох үндэслэл болно.



4.Төлбөрийн буцаалт болон шилжүүлэлт

- 4.1.Төлбөр төлөгдсөний дараа Сургалтанд хүндэтгэн үзэх шалтгаанаар сууж чадахгүй болсон бол эхний хичээлээс ажлын 2 хоногийн өмнө сургалтын менежерт урьдчилан утсаар мэдэгдэнэ.
- 4.2.Хүндэтгэн үзэх шалтгаан, онцгой нөхцөл байдал үүссэн нөхцөлд Төлөөлөгч зөвшөөрвөл дараа ээлжийн сургалтад төлбөрийг 100% шилжүүлэн тооцуулж болно.
- 4.3.Сургалтын эхний хичээл эхэлснээс хойш Суралцагч нь суух боломжгүй болсон тохиолдолд төлбөрийн 80%-с хичээлд суусан цагт хувьчлан тооцож буцаан олгоно. Жишээлбэл хичээлийн жилийн хагасаас гарахаар болсон гэж үзвэл нийт төлбөрийн 80% буюу 1,200,000₮ өөс 50% ийг тооцон 600,000₮ буцаан олгоно.
- 4.4.Төлбөрийн буцаалтыг гэрээ цуцлагдсан сарын 15нд, эсхүл дараа сарын 15ны өдөр олгоно.

5.Хичээл нөхөж орох тохиолдол

- 5.1.Дараах тохиолдолд хичээлийг нөхөн орно.
 - 5.1.1.Нийтээр амрах баярын өдөртэй давхацсан.
 - 5.1.2.Хөл хорио тогтоосон тохиолдолд.
 - 5.1.3.Сургуулийн дотоод үйл ажиллагааны улмаас хичээл ороогүй тохиолдолд.
 - 5.1.4.Цаг агаарын онц аюултай нөхцөл байдал.
- 5.2.Хичээлийг дараах сонголтоор, төлөөлөгч нарын олонхийн саналаар нөхөж орно.
 - 5.2.1. Дараагийн 4 хичээлийг 60 минутаар эрт эхлэх эсвэл сунгах.
 - 5.2.2.Хичээлийн хуваарьт заагдсанаас бусад өдөр хичээллэх.

6.Хичээлийг нөхөж орохгүй тохиолдол

- 6.1.Дараах тохиолдолд хичээлийг нөхөн орох боломжгүй.
 - 6.1.1.Сурагч хоцорсон, тасалсан.
 - 6.1.2.Сурагч эрүүл мэнд, гэр бүлийн шалтгаанты улмаас хичээлд оролцоогүй.

7.Төлөөлөгчийн эрх, үүрэг

- 7.1.Сургалтын агуулгын стандартыг хангуулах талаар шаардлага тавих эрхтэй.
- 7.2.Сургалттай холбоотой санал хүсэлт, гомдол гаргах эрхтэй.
- 7.3.Суралцагч сургалтад бүрэн хамрагдаж хөтөлбөрийн дагуу агуулгыг бүрэн эзэмших, идэвхи санаачлагатай оролцож байгаа эсэх тухай мэдээлэл авах эрхтэй.
- 7.4.Суралцагчийг багш, ажилтнуудаас тавьж буй зүй ёсны тавьсан шаардлага, үүрэг даалгаврыг биелүүлэхэд дэмжих үүрэгтэй.
- 7.5.Гэрээний дагуу хичээлийн ээлж эхлэхийн өмнө Суралцагчийн төлбөрийг бүрэн төлөх үүрэгтэй.
- 7.6.Суралцагчийн тухай сургалтын мэдээллийн хуудсыг үнэн зөв бөглөх (энэ хуудсанд хүүхдийн харшил, эрүүл мэнд, сэтгэл санааны тухай шаардлагатай мэдээллүүд байна) үүрэгтэй.
- 7.7.Суралцагчид хэрэгтэй зөөврийн компьютер, хулгана, цэнэглэгч зэргээр хангах үүрэгтэй.
- 7.8.Зуслангийн зүгээс шаардагдах бүхий л бичиг баримтыг бүрдүүлэх мөн шаардлагуудыг дагаж мөрдөх
- 7.9.Төлөөлөгчид дараах үйлдлийг хориглоно.
 - 7.9.1.Сургалтын цагаас гадуур яаралтай тохиолдол биш үед утастах.
 - 7.9.2.Цахимаар багш нартай холбогдох хүсэлт явуулах, холбогдох.
 - 7.9.3.Багш, бусад ажилтантай зүй бус харьцах. (үгээр, үйлдлээр)
 - 7.9.4.Нээлттэй хичээлээс бусад үед хичээлд суух, хичээлд саад болох.

8.Сургуулийн эрх, үүрэг

- 8.1.Суралцагч болон Төлөөлөгчийн зүгээс гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй.
- 8.2.Суралцагчийн хичээлийн цаг, завсарлага, таралт болон ёс зүйн сахилга хариуцлагад хяналт тавих эрхтэй.
- 8.3.Сургалтын үйл ажиллагааны явцад суралцагчийг гарч болох эрсдэлээс сэргийлэх үүрэгтэй.
- 8.4.Осол гэмтэл гарсан тохиолдолд яаралтай холбогдох байгууллага болон Төлөөлөгчид мэдэгдэх үүрэгтэй.
- 8.5.Сургуулийн эрх бүхий багш, ажилтанд дараах үйлдэл хийхийг хориглоно.
 - 8.5.1.Суралцагчидтай хувийн холбоо тогтоох утас, цахимаар холбогдох.

8.5.2.Суралцагчидтай зүй бус харьцах.

8.5.3.Суралцагчдын хийсэн бүтээл болон зургийг ашиглах.

8.5.4.Эцэг эхтэй хувийн холбоо тогтоох, утас цахимаар холбогдох.

9.Бусад зүйл

9.1.Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

9.2.Гэрээг талууд харилцан тохиролцсон нөхцөлд хугацааг сунгаж болно.

9.3.Гэрээний талуудын хооронд үүссэн аливаа маргааныг Монгол улсын хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

10.Сурагчийн тухай асуулга

10.1.Суралцагч ADHD / Анхаарал сулрах эмгэг/ - тэй эсэх

А. Тийм

Б. Үгүй

10.2.Суралцагч харшилтай эсэх? Тийм бол доор дурдах бөгөөд яаралтай үед хэрэглэгдэх эмийг, зааврын дагуу бичих.

10.3.Суралцагч цагийн хуваарийн дагуу уудаг эмтэй эсэх? Тийм бол доор дурдах бөгөөд хэрэглэгдэх эмийг, зааврын дагуу бичих.

10.4.Суралцагч сэтгэлзүйн болон биеийн эрүүл мэндийн хувьд анхаарах тусгай нөхцөлтэй эсэх? Тийм бол доор дурдах.

10.5.Суралцагч ганцаараа явж болох эсэх. Үгүй бол сурагчийг сургалтаас ирж авах хүмүүсийн нэр утасны дугаар.


а _____

б _____

в _____

г _____

Гэрээ байгуулсан:

ТЭЕ Education- ийн захирагч Б.Билгүүн	Суралцагчийг төлөөлж:
Хаяг: ЧД 5-р хороо бхороолд Оранж Плаза 9давхар 905 тоот	Хаяг:
Утас: 90806161 / 91319101	Утас:
Гарын үсэг: 	Гарын үсэг: